ВИДЕО ШТОРК · 2023 оны 6-р сарын 23

"ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ"-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВИДЕО ШТОРК ХИЙЛЭЭ



Баян-Өлгий аймгийн прокурорын газраас 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 191 мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьж ажилласнаас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.8 дугаар зүйлд заасан "Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах", 16.9 дүгээр зүйлд заасан "Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах" төрлийн 5 мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьж, прокуророос яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлжээ.

Прокуророос насанд хүрээгүй хохирогчдод хамаарах, өсвөр насны яллагдагчдад холбогдох хэргийг судалж, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор видео шторк бэлтгэн хүргэж байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=PRNwyX7fmrw

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1536